



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 317

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол даатгал” ХХК-ийн “Зээлийн эрсдэлийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Автотээврийн хэрэгслийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн тус тус бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Монгол даатгал” ХХК /Ч.Энх-Амгалан/-д үүрэг болгосугай.

3. Дээрх бүтээгдэхүүнүүдийн гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг дээрх компанийн гүйцэтгэх удирдлага болон хавсралтад дурдсан ажилтнуудад анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

F:\ajil 2019\Blank\Togtool.doc

000647



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Монгол даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Зээлийн эрсдэлийн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Зээлийн даатгал
4.	Даатгалын зүйл:	Зээлдэгчийн зээлийн гэрээгээр хүлээсэн зээл төлөх үүргийн гүйцэтгэл
5.	Даатгалын эрсдэл:	Зээлдэгч зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчиж зээлийн төлбөр төлөх хугацааг 60 хоногоор хэтрүүлж төлөөгүй тохиолдолд зээлийн нийт үлдэгдэл төлбөр /үндсэн зээл+хүү, нэмэгдүүлсэн хүү/-ийг даатгагч бүрэн төлж барагдуулах тохиолдлыг даатгалын эрсдэл гэж тооцно
6.	Даатгалын гэрээний хугацаа:	1-8 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	12 бүлэг, 97 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Удирдлагын хорооны хурлын 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 19/11 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Б.Даваасүрэн
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Эрсдэлийн удирдлагын газрын захирал Ц.Мөнхбат, бүтээгдэхүүн хөгжлийн ахлах менежер О.Хүрэлчулуун, бүтээгдэхүүн хөгжлийн менежер Н.Золзаяа



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Монгол даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Автотээврийн хэрэгслийн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Автотээврийн хэрэгслийн даатгал
4.	Даатгалын зүйл:	Даатгуулагчийн өмчлөл, эзэмшилд буй А, В, С, D ангиллын авто тээврийн хэрэгсэл болон нэмэлт тоноглол
5.	Даатгалын эрсдэл:	-Хөдөлгөөний үеийн осол -Байгалийн эрсдэлүүд -Жолоо шилжүүлэх эрсдэл -Хөдөлгөөний бус үеийн осол -Галын эрсдэлүүд -Хулгай дээрмийн эрсдэлүүд -Жолоочийн гэнэтийн ослын гэсэн 7 эрсдэлээс хамгаалах бөгөөд алтан, мөнгөн, ган, уран жолоо гэсэн 4 сонголтоос хамаараад даатгуулагч 3-7 эрсдэлийг сонгох боломжтой.
6.	Даатгалын гэрээний хугацаа:	Даатгалын хугацаа 1 жил хүртэл
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	12 бүлэг, 204 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Удирдлагын хорооны хурлын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 19/10 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Ц.Ган-Эрдэнэ
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Эрсдэлийн удирдлагын газрын захирал Ц.Мөнхбат, бүтээгдэхүүн хөгжлийн менежер О.Хүрэлчулуун, бүтээгдэхүүн хөгжлийн менежер Н.Золзаяа